

нийтлэгдсэн

Олон улсын уралдааны дүн

“Таван цагариг” сонины газраас 2009 онд зарлан явуулсан Шатрын бодлого зохиомжийн ОУХМ Г.Лхагвасүрэн агсны нэрэмжит бодлого зохиох Олон улсын уралдаанд 6 орны 12 зохиогчид: И.Агапов (ОХУ),Е.Богданов (Украин),Г.Бор (Монгол),А.Гаспарян (Армен),Р.Ларин (ОХУ),В.Мельников (Украин), Ж.Симадината (Индонез),Ц.Сэр-Од (Монгол),В.Черных (ОХУ),А.Чистяков (Латви),Е.Фомичев (ОХУ),С.Энхтөвшин (Монгол) нар 15 бүтээл ирүүллээ.

Эдгээрийн зарим нь сэдэвт бус, хоёрдмол нүүдлүүдтэй байсан бөгөөд 6 бодлогыг сонгон авч шалгаруулах саналаа урьдчилан танилцуулсан болно.Уралдааны урьдчилсан дүн 2009 оны 11-р сард www.selivanov.ru сайтад {линк нь:


<http://www.selivanov.ru/download/Awards/Drugje/2009/MTL60Pr.pdf>} тавигдсан бөгөөд оролцогчдод интернетээр мэдэгдсэний дагуу хэлэлцүүлгийн хугацаанд ирсэн шүүмжлэл,мэдээллийг үндэслэн

шагналт байрны үнэлгээ авахаар байсан И.Агапов, Е.Фомичев нарын бодлогыг хэсэгчилсэн өвтэй (В.Марин “Good Comp” IV шан. 1924 он болон С.Левман “Osterrichische Arbeiter Schachzeitung” I шан. 1928 он бодлогуудтай адил зохиогдсон) учир үнэлгээг нь бууруулав.

Тэмцээний эцсийн дүнг товчлон танилцуулбал:

Евгений Богданов

Тэргүүн байр



1.Mbd3! зорилго: 2.Mf2+ (A) !! ef 3.Tr:e2 (B) #
1...Tr:c2 2.Tr:e2 (B)!! зорилго: 3.Mf2 (A) # ;
1...Tr:d3 2.cd+ (C)!! M:d3 3.Tc6 (D) # ;
1...M:d3 2.Tc6 (D)+!! Tr:c6 3.cd (C) #

Сэдвийг цагааны 2 ба 3-р нүүдлүүдийн солигдлоор, 4 хувилбараар харуулсан, сэдэвт төөрөгдүүлэх нүүдэл болон хувьслын нэмэлт тоглоомтой энэ бодлого нь дэлхийн сонгодогуудын эгнээнд багтахаар сайхан бүтээл болжээ.

Владимир Мельников (I хүндэт үнэлгээ), **Рудольф Ларин** (II хүндэт үнэлгээ), **Игорь Агапов** (тусгай хүндэт үнэлгээ), **И.Агапов** (магтаалт үнэлгээ), **Евгений Фомичев** (тусгай магтаалт үнэлгээ)-нд тус тус шалгарлаа.

Уралдааны дэлгэрэнгүй дүнг www.mongolchess.com болон шатрын бодлогын гадаадын сайтуудад тавьж мэдээлэх болно.

Уралдааны шүүгч

Л.ТОГООХҮҮ

(Дэлгэрэнгүй дүнг сайтын LG-60 хавсралтад үзнэ үү)